



ШУТИС-ИЙН ОЮУТНЫ IV БАЙР

# МХТС-ийн оюутны байрын товч танилцуулга

Тус байр нь 1983 онд ашиглалтанд орсон. 54 тасагт 215 оюутан хүлээн авах хүчин чадалтай. Одоо 215 оюутан, байрны эрхлэгч, үйлчилгээний 6 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус байр 2003, 2005, 2007, 2009 онуудад ШУТИС-ийн тэргүүний байраар 4 удаа, 2002 онд Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны “Залуус” төслийн хүрээнд зарлагдсан уралдаанд нийслэл хотод үйл ажиллагаа явуулдаг оюутны дотуур байруудаас шалгарч “Нийслэлийн шилдэг” байр, 2008 онд БСШУЯ, МОХ-оос зарласан уралдаанд шалгарч “Улсын тэргүүний дотуур байр”-аар, 2011, 2012 онуудад ШУТИС-ийн оюутны байрнуудаас II байранд, Байрны Оюутны зөвлөл тэргүүний оюутны зөвлөлөөр шалгарсан.

Тасаг бүр халуун, хүйтэн устай, мебель модон ор, хоолны шүүгээ, ширээ, хүний тоогоор сандалтай. Байрны оюутнуудад 11 хөлдөөгч, угаалын 2 машин, 1 индүү, 2 шүршүүртэй халуун ус, интернет, үзвэрийн өрөө, мэргэжлийн номын санчтай, 1209 төрлийн 2785 ширхэг номтой номын фонд, 26 суудалтай уншлагын танхимтай, давхар бүр ариун цэврийн өрөөтэй. Оюутны байранд бичлэг хийж бичлэгээ удаан хугацаагаар хадгалах боломжтой 6 камер суурилуулж ашиглалтанд оруулж өгсөн.

# Байрны оюутны зөвлөлийн өрөө №220

*Байрны оюутны зөвлөл :*

*Оюутны зөвлөлийн дарга болон 5 гишүүдийн хамт үйл ажиллагаагаа явуулдаг .*



## 4 хүний ортой 54 өрөөтэй



# ***Байрны дотоод үйлчилгээ***

- Номын сан /Бие дааж суралцах танхим, Номын фонд/
- Байрны цагдаа
- Утасгүй интернет
- Хүнсний мухлаг
- Халуун усны өрөө
- Теннис
- Угаалга



## Бие даалтын танхим



1209 төрлийн 2785 ширхэг номтой номын фонд, 26 суудалтай уншлагын танхимтай

## Теннис



Цагийн хуваарь : 16 цагаас 23 цагийн хооронд үнэ төлбөргүй

## Хүнсний мухлаг №106



## *Утасгүй интернет /wifi/*

2012-2013 оны хичээлийн жилд байрны оюутнуудын хүсэлтээр wifi router төхөөрөмж 6 ш тависан.

Байрны оюутнуудад сард 5000 төгрөгний хураамжтайгаар нэр, нууц код өгөн хэрэглүүлдэг.

## Халуун усны өрөө



Халуун усны өрөөг оюутнуудын дундаас шалгаруулж ажилуулах эрх олгодог.

## Ариун цэврийн өрөө

